



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/014/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

**Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,**

**тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхбаатар**

Утас: 261885 Цахим хаяг: [enkhbaatare@audit.gov.mn](mailto:enkhbaatare@audit.gov.mn)

**Ахлах аудитор: Г.Мөнхчимэг**

Утас: 261740 Цахим хаяг: [munkhchimegg@audit.gov.mn](mailto:munkhchimegg@audit.gov.mn)

**Ари файнэнс аудит ХХК-ийн захирал Д.Ариунаа**

Утас: 99088151 Цахим хаяг: [ariun\\_55@yahoo.com](mailto:ariun_55@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ТӨВИЙН БҮСИЙН ХҮНС, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН  
ЦОГЦОЛБОР ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЖАМУХА ТАНАА

2025.03.25 № 07/189  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

НББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх, тасалбар болголт”, нийцсэн бөгөөд зохистой байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Барилгын болон дэд бүтцийн зураг төсөл хийх гэрээт ажлуудын дуусах хугацааг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан боловч “Барилга хөгжлийн төв” ТӨҮГ-аар зураг төсөлд магадлал хийлгэж байна гэсэн шалтгаанаар гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаагүй, гүйцэтгэгч компаниуд ажлын гүйцэтгэлээ ирүүлээгүй,
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 17.0 сая төгрөгийн өр төлбөр, авлагын дансанд бүртгэлтэй 13.8 сая төгрөгийг харилцагч байгууллагагай тооцоо нийлж, баталгаажуулаагүй,

- Компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй "Өндөр ашиг шимтэй сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй"-н шав тавих ёслолын арга хэмжээнд 19.6 сая төгрөгийг зарцуулсан,
- "Алтан хөхий очир" ХХК-д олгуулахаар тогтоосон 69.8 сая төгрөгийн шүүхийн шийдвэрийг хяналтын шатанд давж заалдаагүйн улмаас 9.6 сая төгрөгийн алданги төлж үргүй зардал гаргасан байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 2022 оны 08 дугаар тогтоолоор төслийн үйл ажиллагааг таслан зогсоох шийдвэр гарч 2022, 2023 онд санхүүжилт саатсан, 2024 онд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу төлбөр тооцоо гүйцэтгэх түр журмын хугацааг сунгах арга хэмжээ авсны үр дүнд 2024 онд 1,420.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэрийг "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж өөрчилсөнтэй холбоотой "Цэвэрлэх байгууламжийн зураг төсвийн ажил"-ын зураг, төсөвт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тул уг асуудлыг Төлөөлөн Удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлэхээр хурал товлосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

"Төвийн бүсийн хөнгөн, хүнсний үйлдвэрлэл технологийн цогцолбор" ТӨХХК-ын бүтээн байгуулалтын төслийн ажилд 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 7,144.5 сая төгрөг батлагдсанаас автозамын ажилд 5,729.4 сая төгрөг, төслийн талбайн хамгаалалтын хашаа хийх ажилд 900.3 сая төгрөг, автозамын техник, технологийн хяналт зөвлөх үйлчилгээний ажилд 265.5 сая төгрөг, гадна холбоо, дохиололын ажилд 249.2 сая төгрөг тус тус баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,098,094,193.96	595,946,940.15
1.1.2	Дансны авлага	58,672,352.05	27,491,900.00
1.1.6	Бараа материал	673,061,283.00	801,785,283.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,513,777,684.00	4,361,558,934.00
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,343,605,513.01</b>	<b>5,786,783,057.15</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	66,216,017.93	56,482,412.33
1.2.2	Биет бус хөрөнгө	194,975,000.06	206,108,333.42
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>261,191,017.99</b>	<b>262,590,745.75</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,604,796,531.00</b>	<b>6,049,373,802.90</b>
2.1.1.1	Дансны өглөг	3,014,508,924.00	1,522,854,562.50
2.1.1.3	Татварын өр	3,184,303.20	100.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	181,430.00	
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,017,874,657.20</b>	<b>1,522,854,662.50</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,017,874,657.20</b>	<b>1,522,854,662.50</b>
2.3	Эздийн өмч	4,200,000,000.00	4,200,000,000.00
2.3.1	Төрийн өмч	4,200,000,000.00	4,200,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(613,078,126.20)	326,519,140.40
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,586,921,873.80</b>	<b>4,526,519,140.40</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>6,604,796,531.00</b>	<b>6,049,373,802.90</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Хүүгийн орлого	166,807,249.06	122,975,182.88
2	Бусад орлого		1,420,417,326.50
3	Ерөнхий ба удирдлагын зардал	721,857,991.35	647,856,857.10
4	Бусад зардал		9,630,219.00
5	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	141,498,000.00	40,358,500.00
6	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(413,552,742.29)</b>	<b>926,263,933.28</b>
7	Орлогын татварын зардал		
8	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(413,552,742.29)</b>	<b>926,263,933.28</b>
9	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(413,552,742.29)</b>	<b>926,263,933.28</b>
10	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(413,552,742.29)</b>	<b>926,263,933.28</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>457,675.00</b>	<b>1,420,959,240.50</b>
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		1,420,417,326.50
1.1.6	Бусад мөнгөн орлого	457,675.00	541,914.00
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>815,635,633.19</b>	<b>2,077,265,129.24</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	389,350,815.00	326,692,034.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	114,652,887.36	91,727,469.79
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,681,839.00	9,298,106.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	19,800,000.00	-
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,560,500.00	-
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	13,798,990.58	15,195,436.98
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	42,069,704.00	35,421,110.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	212,720,897.25	1,598,930,972.47
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(815,177,958.19)</b>	<b>(656,305,888.74)</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	138,742,142.21	154,158,634.93
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	138,742,142.21	154,158,634.93
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>7,599,900.00</b>	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,599,900.00	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>131,142,242.21</b>	<b>154,158,634.93</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(684,035,715.98)	(502,147,253.81)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,782,129,909.94	1,098,094,193.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,098,094,193.96	595,946,940.15

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,200,000,000.00		(202,069,348.35)	3,997,930,651.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			2,543,964.44	2,543,964.44
3	Залруулсан үлдэгдэл	4,200,000,000.00	-	(199,525,383.91)	4,000,474,616.09
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			(413,552,742.29)	(413,552,742.29)
5	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,200,000,000.00	-	(613,078,126.20)	3,586,921,873.80
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			13,333,333.32	13,333,333.32
7	Залруулсан үлдэгдэл	4,200,000,000.00	-	(599,744,792.88)	3,600,255,207.12
8	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			926,263,933.28	926,263,933.28
9	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,200,000,000.00	-	326,519,140.40	4,526,519,140.40

## 2.5 Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт орлого:</b>	<b>1,920,872,052.15</b>	<b>41,460,053,391.96</b>	<b>2,664,809,643.09</b>	<b>38,795,243,748.8</b>	<b>6.4</b>
Дүрмийн сан	1,782,129,909.94	1,098,094,193.96	1,098,094,183.96	10.00	100.0
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	-	11,907,400,000.00	-	11,907,400,000.0	-
ЗГ-ын хөрөнгө оруулалт	-	28,369,559,198.00	1,420,417,326.50	26,949,141,871.50	5.0
Хүүний орлого	138,742,142.21	85,000,000.00	146,298,132.63	(61,298,132.63)	172.1
<b>Нийт зардал</b>	<b>822,777,858.19</b>	<b>41,284,911,549.50</b>	<b>2,068,862,702.94</b>	<b>9,216,048,846.56</b>	<b>5.0</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>739,477,858.19</b>	<b>922,352,351.50</b>	<b>648,445,376.44</b>	<b>273,906,975.06</b>	<b>70.3</b>
Татварын өмнөх ашиг алдагдал	-	-	-	0.00	-
Цэвэр ашиг/алдагдал	-	-	-	0.00	-
Хөрөнгө оруулалт:	83,300,000.00	40,362,559,198.00	1,420,417,326.50	38,942,141,871.5	3.5
Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс:	83,300,000.00	85,650,000.00	-	85,650,000.00	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	-	11,907,350,000.00	-	11,907,350,000.00	-
50.0 тэрбумын санхүүжилт	-	28,369,559,198.00	1,420,417,326.50	26,949,141,871.50	5.0
Нийт өглөг:	-	-	1,522,851,562.50	(1,522,851,562.50)	-
Нийт авлага:	-	-	-	0.00	-
Авлага	-	126,500.00	27,488,900.00	(27,362,400.00)	-
Ажиллагсдын тоо	11	9	6	3	66.7
Цалингийн сан	546,073,406.36	574,671,119.50	462,648,758.00	112,022,361.50	80.5
Ажиллагсадын дундаж цалин	2,757,946.50	2,520,487.37	2,409,628.95	110,858.42	95.6

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,799,092.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,799,092.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Сахилгын шийтгэл ногдуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны эцэст нийт 17,000.0 мянган төгрөгийн өр төлбөр, 13,860.0 мянган төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	30,860.0			1	30,860.0				
"Алтан хөхий очир" ХХК-д олгуулахаар тогтоосон 69,786.6 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрийг хяналтын шатанд давж заалдаагүйн улмаас 9,630.2 мянган төгрөгийн алдангийг төлсөн байна.	1	9,630.2			1	9,630.2				
БНБУ-ын зочин төлөөлөгчдийг хүлээн авч, хурал зохион байгуулах, шав тавих ёслолын арга хэмжээнд оролцохтой холбогдох зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	19,600.0			1	19,600.0				
Барилгын зураг, дэд бүтцийн зураг төсөв хийх төслийн ажлуудын гэрээ 2024.12.31 хүртэл сунгагдсан боловч ажлын гүйцэтгэлээ ирүүлээгүй, мөн тухайн компанийн нэр, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөж байгаатай холбоотой дээрх зураг төслүүдийг цаашид ашиглахгүй байх эрсдэл үүссэн байна.	1	1,739,002.6			1	1,739,002.6				
ТУЗ-ийн хараат бус гишүүдийг томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулаагүй, ТУЗ-ын хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнд тухайн байгууллагын хэрэгжүүлж байгаа төсөлтэй холбоотой инженер, техникийн мэргэжлийн хүн оруулаагүй байна.	1						1			
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1,799,092.8</b>			<b>4</b>	<b>1,799,092.8</b>	<b>1</b>			

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.